170

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategresthural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.11.19 № 35

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

Улсын Их Хурлын тогтоолын
хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин наймдугаар зүйлийн 28-ийн 2, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хорин наймдугаар зүйлийн 28.2 дах хэсэгт тус тус заасны дагуу 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой зарим компанийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах үүрэг бүхий түр хороо тайлан, санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулснаар татан буугдан 2024 оны нэгдүгээр сарын 16-ны өдөр УИХ-ын 9 дүгээр тогтоол гарсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 1-ийн 2-т "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж, хорин тавдугаар зүйлийн 1-ийн 8-д "Улсын Их Хурал ..... дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах;" гэж, дөчин нэгдүгээр зүйлийн 41-ийн 1-т "Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна." гэж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн наймдугаар зүйлийн 8.1.13-т "Гишүүн дараах бүрэн эрхтэй: Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад асуулга, асуулт тавьж, хариуг хуульд заасан хугацаанд авах;" гэж, гучин долдугаар зүйлийн 37.1.2-т "Улсын Их Хурлын хянан шалгах ажил нь Засгийн газрын хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах үйл ажиллагаа болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын хууль биелүүлэх үйл ажиллагаанд хяналт тавихад чиглэх бөгөөд Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ дараах арга хэрэгслээр хэрэгжүүлнэ: асуулга тавих;" гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Хууль тогтоомжийн биелэлтийг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэн талаар тодруулах, хуульд заасан үйл ажиллагаа явуулахыг шаардаж гишүүнээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, ... бичгээр хандсаныг "асуулга" гэнэ." гэж тус тус заасны дагуу Улсын Их Хурлын 2024 оны 9 дүгээр тогтоолын хэрэгжилтийг заалт тус бүрээр гаргаж ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Б.ЭНХБАЯР

2024009977